



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 42

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас ИНЕГ-ын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2018.01.09-ний өдөр байгууллагын шатахууны үлдэгдэлд биет тооллого хийхэд 277 кг шатахуун санхүүгийн тайлангийн үлдэгдлээс илүү байв. Энэ нь сав цэвэрлэх шатахууныг санхүүгийн тайланд бараа материалаас хассан атлаа биетээр зарцуулаагүй үлдэгдлээр байгаатай холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй” гэсэн заалтуудыг үндэслэн

ШААРДАХ нь:

2518043

1. Зарлагадаагүй шатахууныг 2018 оны эхний улирлын санхүүгийн тайланд орлого авч залруулан, аудитаар илэрсэн 912,992 /Есөн зуун арван хоёр мянга есөн зуун ерэн хоёр/ төгрөгийн зөрчлийг арилгах

2. Албан шаардлагын биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт 2018.04.20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ИНЕГ-ын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудын төсвийн захирагч Н.Баярхүү, нягтлан бодогч Д.Одончимэг нарт хариуцуулав.



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 47

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн бараа материалд бүртгэлтэй 3,5 сая төгрөгийн өвс, 11,9 сая төгрөгийн мал амьтанг 2017 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор тоолоогүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг ... жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ. гэснийг зөрчсөн байна.



Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.7 “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалыг тоолж, тооллогын бүртгэлийн үр дүнг хэлэлцэж, протоколоор баталгаажуулж, санхүүгийн тайланд холбогдох баримтыг үндэслэн залруулах

2518053

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.04.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Өлзийт сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Энхболд , нягтлан бодогч Ч.Сүрэнлхам нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ
ӨГСӨН¹:
АХЛАХ АУДИТОР  Б.ДОЛЖМАА
ЗӨВШӨӨРСӨН:
6417143544

ӨЛЗИЙТ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  О.ЭНХБОЛД
НЯГТЛАН БОДОГЧ  Ч.СҮРЭНЛХАМ
БГ 10003 9007911

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.